



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐᠒5 оны ᠖8 сарын ᠒᠒ өдөр

Дугаар А/᠒᠑᠑

Улаанбаатар хот

### Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газрын данс бүртгэлээс барилга байгууламж хасах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/81 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/895 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сэлбэ дэд төвийн газар чөлөөлөлтийн бүсэд орсон Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газрын баланст бүртгэлтэй нийт 23,901,070.00 (хорин гурван сая есөн зуун нэг мянга дал) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан барилга байгууламжийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газар (Ө.Энхбаяр)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй барилга байгууламжийг буулгах, хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж, нийт 496,000.00 (дөрвөн зуун ерэн зургаан мянга) төгрөгөөр худалдан борлуулж, нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул), өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлтийг хийхийг Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газар (Ө.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА



В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн А/152 дугаар тушаалын хавсралт

ДАНС БҮРТГЭЛЭЭС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон но	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Акталж данснаас хасах үндэслэл	Хоёрдогч түүхий эдийн үнэлгээ
1	Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хорооны Хандгайтын 29-250 тоот гудамжны гүний худгийн барилга	15	м2	9	9,000,000.00	6,225,000.00	2,775,000.00	Сэлбэ дэд төвийн газар чөлөөлөлтийн бүсэд өртсөн	248,000.00
2	Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хорооны талбайн 3-584 тоотын гүний худгийн барилга	17	м2	9	14,901,070.00	11,796,680.12	3,104,389.88	Сэлбэ дэд төвийн газар чөлөөлөлтийн бүсэд өртсөн	248,000.00
Нийт дүн					23,901,070.00	18,021,680.12	5,879,389.88		496,000.00